



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 456

Дэлгэрхаан сум

Төрийн бус байгууллагуудын үйл
ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2.1.2.2 дахь хэсгийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "Алтан цом-2026" спортын наадамд оролцогчдод тэмцээний зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөг, сумын харъяат боловсрол судлалын магистр, зөвлөх багш Д.Эрдэнэчулуунд хүндэтгэл үзүүлэхэд 1,000,000 (нэг сая) төгрөг, аймгийн аварга шалгаруулах ахмад гар бөмбөгийн тэмцээнд дэмжлэг үзүүлэхэд 1,000,000 (нэг сая) төгрөг, шагайн холбоонд аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход 500,000 (таван зуун мянга) төгрөг, нийт 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Арга хэмжээнүүдийн зохион байгуулсан зурагт тайлан холбогдох мэдээллийг гаргаж ирүүлэхийг Улаанбаатар хот дахь залуучуудын холбооны тэргүүн (А.Хувьзаяа), шагайн холбооны тэргүүн (Э.Лувсандамбийжанцан) нарт даалгасугай.

3.Зардалд шаардагдах 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бодогч (О.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА  Б.ӨНХ-АМГАЛАН

2376010113

